



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ ОРНЫ ГАЗАРЗҮЙН АСУУДАЛ

№11 (27)

Улаанбаатар 2015

ГАРЧИГ	
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ШИНЖ ЧАНАР, ХАРИЛЦАН НӨЛӨӨЛӨЛ	9
Дорнод Монголын хөрсөн дэх хүнцэл (As) ба хөрсний шинж чанар (О.Батхишиг, Н.Нямсамбуу, Г.Бямбаа, Ө.Ганзориг, Б.Энхбаяр, П.Нямбаяр)	9
✓ Зүүн бүсийн ландшафт ашиглалтын өнөөгийн төлөв байдал (Э.Авирмэл, Д.Энхтайван, О.Мөнхдулам, Б.Баянжаргал)	18 ✓
Хөрсний механик бүрэлдэхүүнээс хамааралтай чийгийн горим (Г.Бямбаа, Ц. Болормаа)	25 ✓
✓ Хээрийн бүс дэх хужир, мараат ландшафтын тархалтын онцлог: Монгол орны зүүн бүсийн жишээн дээр (Ц.Батням, Б.Баянжаргал)	31 ✓
Богино долгионт цацрагийн хуваарилалтад үзүүлэх хотгор гүдгэр, газрын бүрхэвчийн нөлөө (А.Дашцэрэн)	35
✓ Хэнтий аймгийн нутаг дэвсгэрийн хотгор гүдгэрийн онцлог, морфогенетик хэв шинж (Б.Баянжаргал, М.Нямхүү, Ц.Батням, Д.Энхтайван)	43 ✓
Монгол орны хөрсний гадаргын бүрхэвчийн дулаан тусгаарлалт (Н.Шархүү, Ш.Анармаа)	52
Хөрсний чийг хамгаалах навч болон элсэн хучаас (Д.Ихбаяр, Г.Элбэгзаяа)	61
Буянт голын сав газрын хөрсний зарим хүнд элементийн судалгаа (Д.Батцэцэг, Ч.Лхагвасүрэн, О.Батхишиг)	67
✓ Современное состояние плодородия почвенного покрова агроэкосистем Западно-Казахстанской области (Т.К.Салихов, Ё.Ж.Гармаев)	73
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ҮНЭЛГЭЭ, СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ	79
Хотын орон зайн үндсэн хэмжилтүүд (Улаанбаатар хотын жишээн дээр) (П.Мягмарцэрэн, И.Мягмаржав, С.Мөнхнаран, Г.Давшил, Ч.Заяа, Н.Энхтуяа, Д.Ганпүрэв)	79
Хүн амын шилжих хөдөлгөөний судалгааны онол аргазүйн асуудалд (Ж.Оюунгэрэл)	85
Дефляцийн эрчмийг уур амьсгалын зарим үзүүлэлтээр тооцох (Т.Даваагатаан, М.Нямхүү, Д.Энхтайван)	91
Хөрсний дулаан дамжуулалтын коэффициентийг тооцох нь (З.Мөнхцэцэг, Г.Чулуунбаатар, Ё.Амарбаясгалан)	95
✓ Бэлчээрт ашиглах талбайг тодорхойлоход газрын гадаргын онцлогийг харгалзан үзэх аргазүйн асуудал (Хэнтий аймгийн жишээн дээр) (М.Нямхүү, Б.Баянжаргал, Д.Энхтайван)	102
Зудын нөхцөл түүний үр дагаврыг тодорхойлох газарзүйн асуудлууд (Өвөрхангай аймгийн жишээгээр) (А.Амармэнд, Н.Болдбаатар, Д.Сайнбаяр)	110

ЗҮҮН БҮСИЙН ЛАНДШАФТ АШИГЛАЛТЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Э.Авирмэд¹, Д.Энхтайван¹, О.Мөнхдулам¹, Б.Баянжаргал¹

¹ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Физик газарзүйн салбар

Abstract

In this paper we raised issues related to present land use, change in land use and landscape territorial utilization in the Eastern Mongolia. The area is characterized by a shortage of **surface** water sources, aridity and high frequency of natural hazards, soil erosions, and is susceptible to soil damage. The region has 199,514 population with low density of 0,69 per km². A total of 181753 hectares of cropland were affected by the mining extraction 2073.7 hectares. In the eastern region 21235.4 hectares of grazing land feed 7,480,464 heads of livestock. 37 heads livestock in 100 hectare grazing land in this region was lower than the country average by 9 heads. Due to low population density and smaller number of livestock the environment of the region was relatively intact.

Түлхүүр үгс: Улсын тусгай хамгаалалттай газар, бэлчээр, ой, газар тариалан, эдэлбэр газар, уул уурхайн ашиглалтын бүс

Оршил

Сүүлийн жилүүдэд Дорнод Монголын талд экологийн өөрчлөлт хүчтэй илрэх болжээ. Экологийн доройтлын үндсэн шалтгаан нь зөвхөн бэлчээрийн өвс ургамал талхлагдаж, хөрс элэгдэж эвдэрсэнтэй холбоотой төдийгүй мөн ой, хээрийн түймрийн давтамж олширч хамрах хүрээ ихэссэнтэй шууд холбоотой юм. Энэ бүс нутаг гадаргын усны нөөц ихээхэн дутмаг, хуурайшилт, байгалийн гамшигт өртөх магадлал өндөртэй, хөрсөн бүрхэвч нь элэгдэл, эвдрэлд амархан өртөмтгий юм. Монгол улсын зүүн бүс нь байгалийн нөөц, чадавх сайтай, ашиглалт их биш газар нутаг боловч унаган байгаль нь эмзэг тогтвортой биш, элэгдэл эвдрэл, алдралд амархан ордог, байгальд үзүүлэх хүний сөрөг нөлөөлөлд тогтворгүй нутаг юм. Зүүн бүсийн аймгууд нь бэлчээрийн хүрэлцээ сайтай, мал цөөнтэй. Бэлчээрийн дундаж ачаалал бага, малын нягтшил бага сийрэг байрлалтай ч гэсэн тодорхой хэсэгт бэлчээрийн талхагдал нэлээд гарч байна. Нутгийн баруун урд ба урд хэсгээр цөлжилт идэвхжиж Дорнод Монголын талын 500-900 км өргөн байсан хамгаалалтын зурвас алдралд орж 200-300 км болж нарийсаад байна. Монгол орны хэмжээнд зөвхөн Зүүн бүсэд тариаланд тохиромжтой үржил шим бүхий 350.0 орчим мян.га атар нутаг үлдсэн байна. Дэлхийн хялганат хээрийн экосистемийн загвар болгон хадгалах зорилгоор Зүүн бүсийн 14 газар нийтдээ 2688.2 мян.га буюу нутгийн 9.4 хувийг тусгай хамгаалалтад аваад байна.

Судлагдсан байдал

Германы эрдэмтэн Х.Рихтер, Х.Бартель, Г.Хаазе нар 1959 онд монгол орны дорнод хэсэгт ландшафтын судалгаа явуулж дорнод монголын ландшафтын голлох онцлог шинж нь хотгор гүдгэрийн хэлбэрээс болж нэг маягтай байдаг [1] гээд дорнод монголыг Хэнтий, түүний салбар уулс, Дорнод монголын бэгэлцэгт талархаг нутаг, Дорнод монголын говь гэсэн 3 том ландшафтын ялгаатай нутгууд болгон ангилсан байдаг юм. Ландшафтын судалгааг 1962-1963 онуудад Академич Ш.Цэгмид монгол

орны дорнод хэсэгт явуулж тус районд өндөр уулын, дундаж уулын, нам уул-талын бүлэгт хамаарах 19 төрлийг ландшафтыг ялган тодорхойлолт өгч монголын дорнод хэсэгт уулархаг ойт хээрийн бүс, хуурай хээрийн бүс тодорхой үзэгдэх боловч хотгор гүдгэр уг бүсүүдийн оршилт, төрх байдалд их нөлөөлдөг тул хотгор гүдгэрийн хэвшинж ландшафтын төрх байдлыг тодорхойлно гэж үзэж болно [2] гэжээ. Мөн 1990 онд Үндэсний атласт ландшафтын зураг зохиогдож орсон ба 2014 онд “Хэнтий аймгийн нутаг дэвсгэрийн ландшафт ашиглалт, зохистой бүсчлэл” сэдэвт эрдэм шинжилгээний тайлан бичигдсэн байна. Хэнтий аймгийн нутаг дэвсгэр нь уул уурхай, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл маш эрчимтэй явагдаж байгаа бүс нутаг юм. Судалгааны үр дүнд тус бүс нутагт хатуу хамгаалалтанд байдаг дархан цаазат газар, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн бүсээс гадаргын эвдрэлд хамгийн их нөлөөлөл үзүүлж байгаа уул уурхайн ашиглалтын бүс хүртэл газар ашиглалтын 6 бүсийг ялгасан байна [3].

Судалгааны материал, арга зүй

Судалгааны гол материал нь тус салбарт 2014, 2015 онд хэрэгжүүлж буй “Ландшафтын бүтэц өөрчлөлт, төлөвлөлт (Монгол орны зүүн бүсийн жишээн дээр)” сэдвийн судалгааны хүрээнд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт явуулсан ландшафт, ашиглалтын өнөөгийн төлөв байдал, хувьсал өөрчлөлтийн хээрийн судалгааны материал юм. Байгаль-нутаг дэвсгэрийн ашиглалтын судалгааны ерөнхий аргазүйн үндэс нь байгаль-нутаг дэвсгэрийн ашиглалт, байгалийн цогцолборуудын хувьсал өөрчлөлт, түүнд үзүүлж байгаа нийгэм эдийн засгийн нөлөөллийн үр дагавар болох хүн-байгаль - аж ахуйн үйл ажиллагааны нэгдэл болно [10]. Энэхүү судалгааны хүрээнд байгаль орчны хувьсал өөрчлөлт, хүний үйл ажиллагааны нөлөөний улмаас зүүн бүсийн байгаль нутаг дэвсгэрийн өнөөгийн байдал хэрхэн өөрчлөгдөж буйг судлаж байгальд үзүүлэх сөрөг нөлөөллийг тооцох, төлөвлөх цаашид хамгаалах, хадгалан үлдээх, өнөөгийн ашиглалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгсөн бөгөөд энэ нь бүс нутгийн ландшафт нутаг дэвсгэрийн төлөвлөлтөнд үндэслэн, нутаг дэвсгэрийг бүсчлэн хөгжүүлэх үндэслэл болно. Байгаль ашиглах болон уул уурхай, үйлдвэр, шинэ хот суурин байгуулахад эхлээд ландшафт нутаг дэвсгэрийн төлөвлөлт хийж байгальд үзүүлэх хүний сөрөг нөлөөллөөс гарах үр дагаврыг урьдчилан тооцож байгальд үзүүлэх хор нөлөө багатай арга хэмжээг хэрэгжүүлэх нь байгаль ашиглалтын өнөөгийн гол шаардлага болж байна. Ландшафтын төлөвлөлтийн үндсэн зорилго нь тухайн газар ашиглагч хэсгийн оролцоотойгоор байгалийн нөөц баялгийг хамгаалахад оршиж байна [11]. Ландшафт-нутаг дэвсгэрийн ашиглалтын өнөөгийн төлөв байдлын судалгааг энэ бүсийн хэмжээнд явуулж ландшафтын хувьсал өөрчлөлт, нөлөөлж буй хүчин зүйлүүдийг илрүүлж, улмаар байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах, ландшафтын зохистой бүсчлэлийг тогтоох үндэслэл боловсруулах зорилт тавьсан болно.


Судалгааны ажлын үр дүн

Судалгаанаас үзэхэд Монгол орны зүүн бүс нь Дагуурын уулын хээр, Дорнодын талын жинхэнэ хээр, Хэнтийн уулсын ой тайга болон ойт хээр гэсэн байгалийн олон бүсүүдийн заагт шилжилтийн өвөрмөц экосистемийг бүрдүүлдэг нутаг. Газар тариалангийн томоохон бүс нутаг төдийгүй нүүрс, уран, нефтийн арвин нөөцтэй тул олборлолтод их хэмжээгээр өртөж газрын бүрхэвч, ландшафтад нилээд өөрчлөлт гараад байгаа, цаашид ч өртөх магадлал ихтэй бүс нутаг юм. Судалгаанаас үзэхэд зүүн бүсийн зарим нутагт байгаль ашиглалтын даац хэтэрч нутаг дэвсгэрийн төлөвлөлт хийж

ашиглах шаардлага зүй ёсоор тавигдах болсон байна. Иймээс хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг нарийвчлан судлаж, байгаль-ландшафт-гадаргын өөрчлөлтөнд үнэлгээ өгөх цаашид энэ бүсийн байгалийн нөөц баялагийг зохистой ашиглах, үр ашигтай, байгальд хор хөнөөл багатай урт удаан хугацаанд тогтвортой ашиглах, нөөц баялаг, ашигт малтмалыг авч ашиглахдаа байгалийг нь сүйтгэсэн, эвдсэн, өөрчилсөн тохиолдолд нөхөн сэргээлт хийх, устаж алга болохоор бол хамгаалах арга хэмжээ авах, цаашдаа ландшафтын даац, нөөц, багтаамжид тулгуурласан ландшафт-нутаг дэвсгэрийн төлөвлөлт хийх шаардлагатай [9].

Зүүн бүсийн газар ашиглалтын өнөөгийн төлөв

Энэ бүс нутаг нийтдээ 28620.9 мян.га талбайтай бөгөөд Монгол Улсын газрын сангийн 18.3 хувь болж байна.



Зүүн бүс нутгийн газар ашиглалтын байдлыг газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзвэл:

- Хөдөө аж ахуйн газар нь нийт 22702.0 га байх ба үүний 21235.4 га талбайг буюу 93.5%-ийг бэлчээр эзэлнэ. Бэлчээрийн эдэлбэр газрын 85 хувь буюу 9189281.7 га талбайг өвөл-хаврын, 45 хувь буюу 12204014.7 га талбай зун-намрын бэлчээрт оногдоно. Энэ бүс нутагт хадлангийн талбай 1216300 га, харин тариалангийн талбай 181753 га бий. Үүнээс үр тариа тариалсан талбай 15381.0 га, төмс хүнсний ногоо тариалсан талбай 1161.5 га байна. Тэжээлийн ургамал тариалсан 2597,2 га талбайтай. Атаршуулж хаясан талбай 53877,6 га талбайтай. Уриншилсан 20218,8 га, өнжөөсөн 44899,9 га талбайтай. Усалгаатай газар тариалан байхгүй.
- Хот тосгон бусад суурин газрын нийтийн эдэлбэр газар 32765.30 га. Үүний 259.7 га нь оршуулга, 2306.7 га хог хаягдлын талбайд ноогдоно.
- Уул уурхайн эдэлбэр газар 2073.7 га. Үүнээс ашигт малтмал олборлож байгаа 119260 га, суурьшлын бүсийн барилга байгууламжийн газар 64.2 га байна.

- Зам шугам сүлжээний газарт 34050.50 га, үүнээс авто замын доорх газарт 29138.60 га хамрагдах ба үүнээс улсын чанартай авто замын доорх газар 6816.8 га, төмөр замын доорх газар 213.0 га, орон нутгийн чанартай авто замын газар 21085.5 га, аж ахуйн нэгж байгууллагын дотоодын зориулалттай зам 1157.3 га байна. Авто тээврийн барилга, байгууламж, зогсоолын талбай 79 га, төмөр замын газар бүгд 213.0 га, төмөр замын далангийн талбай хамгаалалтын зурвас газар 213 га байна. Шугам сүлжээний газар бүгд 4612.9 га байна.
- Ойн сан бүхий газар тус бүсэд 1132693.90 га байна. Ой модоор бүрхэгдсэн газар 980894.7 га, ой модыг огтолсон газар 1507.4 га, мод үржүүлгийн газар 12.0 га бий.
- Усан сан бүхий газар нь нийтдээ 18905.10 га талбай эзэлнэ. Нийт сав нутгийн 0,49 хувийг эзэлнэ. Үүнээс гол мөрний эзлэх газар 14249.6 га, нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар 3835 га, горхи, булаг, шандын эзлэх газар 820.5 га байна.
- Улсын тусгай хэрэгцээний газар 1327970.30 га, үүнээс улсын тусгай хамгаалалттай газар 1000616.0 га бий. Үүнээс дархан газар 461727.0 га, байгалийн цогцолборт газар 369260.0 га, байгалийн нөөц газар 169629.0 га, байгалийн дурсгалт газар 3913 га байна. Улсын хилийн зурвас газар 141593.0 га, Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон 114.3 га газар байна.

Зүүн бүсийн газар ашиглалтын бүсүүд

Зүүн бүсийн нутаг дэвсгэр нь уул уурхай, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл маш эрчимтэй явагдаж байгаа бүс нутаг юм. Энэ бүс нутагт дархан цаазат газар, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн бүсээс гадаргын эвдрэлд хамгийн их нөлөөлөл үзүүлж байгаа уул уурхайн ашиглалтын бүс хүртэл газар ашиглалтын 6 бүс ялгарч байна.

1. Улсын тусгай хамгаалалттай газрын: Улсын тусгай хамгаалалттай газрын бүсэд Дархан газар 4, байгалийн цогцолборт газар 3, байгалийн нөөц газар 10, байгалийн дурсгалт газар 4 орж байна.

Дархан цаазат газрын бүсэд: Хан Хэнтийн дархан цаазтай газраас 59,4 га, Нөмрөгийн ДЦГ 320,982 га, Монгол дагуурын ДЦГ (А.Б бүс) 108,154 га, Дорнод Монголын ДЦГ 103016 га газар орно. 589,906 [13. 14].

Байгалийн цогцолборт газрын бүсэд Онон-Балжийн байгалийн цогцолборт газар (А.Б бүс) 400,469 га, Дарьгангын байгалийн цогцолборт газар 64,548 га, Өндөрхаан уулын байгалийн цогцолборт газрын 8,820 га талбай орно. [13. 14]

Байгалийн нөөц газрын бүсэд: Тосон Хулстай байгалийн нөөц газрын 458,510 га, Хар ямаат уулын байгалийн нөөц газрын (БНГ) 50,691 га, Хэрлэн тооно уулын БНГ 4,461 га, Лхачинвандад уул 58,663 га, Угтам уул 46,023 га, Яхь нуур 251,218 га, Онгон таван булаг 9,939 га, Баянцагааны тал 332,362га, Дархан уул 4,854 га, Хэрлэн Тооно уулын байгалийн нөөц газрын 4,461 га талбай орно [13. 14].

Байгалийн дурсгалт газрын бүсэд: Шилийн Богд уулын 18,137 га, Биндэрьяахан уулын 5,736 га, Дарханхаан уулын 2,774 га, Хангал нуурын 3,913 га байгалийн дурсгалт газар орно [13, 14]. Эдгээр тусгай хамгаалалттай газар нутагт таг, уулын тайга, ой, уулын хээрийн, хээрийн ландшафт зонхилно.

2. Ойн ашиглалтын бүс: Зүүн бүсийн нутагт ой 1307,2 мянган га талбайг эзэлнэ. Энэ нь монгол орны ойн талбайн 14,2 хувийг эзэлнэ. Зүүн бүсийн 3 аймгаас Хэнтий, Дорнод аймаг ойн нөөцтэй. Сүхбаатар аймагт ойн нөөц байхгүй. Хэнтий аймагт

монгол орны ой модны 11 хувь байдаг бөгөөд аймгийн нутаг дэвсгэрийн 1132,7 мянган га-г ойн сан эзэлж байна. Хэнтий аймгийн нутаг дэвсгэрийн 14,1% ойгоор бүрхэгдсэн байна. Батноров, Батширээт, Баянмөнх, Биндэр, Дадал, Жаргалтхаан, Норовлин, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сум ойтой [3].



Дорнод аймагт монгол орны ой модны 0.7% хувь байдаг бөгөөд аймгийн нутаг дэвсгэрийн 174,4 мянган га-г ойн сан эзэлж байна. Дорнод аймгийн нутаг дэвсгэрийн 1.41% ойгоор бүрхэгдсэн байна. Баяндун, Баян-Уул, Гурванзагал, Дашбалбар, Халх гол, Цагаан-Овоо, Чойбалсан, Чулуунхороот сум ойтой.

3. Бэлчээр ашиглалтын бүс: Зүүн бүсэд бэлчээрийн газар 21235,4 мян.га байх бөгөөд 7480464 толгой малтай. Энэ бүсэд аж ахуйн үйл ажиллагаа эрчимтэй явагдаж байгаа экологийн нутаг дэвсгэр хамрагдана. Хүний үйл ажиллагааны нөлөөнд бага өртдөг хээр, талын ландшафт давамгайлна. Аж ахуй, ашиглалтын гол чиглэл нь мал аж ахуй юм. 2014 онд зүүн бүсийн нутагт 7 480 464 толгой мал тоологдсоноос адуу 528307, үхэр 578229, хонь 3 653 442, ямаа 2 603 490, тэмээ 13209 байна. Зүүн бүс нийтдээ 61718 өрхтэй, үүннээс 24575 малчин өрхтэй [4, 6, 8].

4. Уул уурхайн ашиглалтын бүс: Аж ахуйн ашиглалтын үндсэн төрөл нь уул уурхайн үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл юм. Эдгээрт үндсэндээ голын хөндий, тал хээрийн ландшафт зонхилно. Энэ бүсэд уул уурхайн 119260 га талбайд олборлолт хийж байгаа ашиглалтын лицензтэй 214 газар бий. Ашигт малтмалын судлагдсан орд, илэрц, газрын тос, төмөр, хар тугалга, уран, цайр, цагаан тугалга, шохойн чулуу, занар, жонш, хоолны давс, гянтболдын улсын батлагдсан нөөцийн 58.5-90 гаруй хувь нь Зүүн бүс нутагт байна. Дорнод аймгийн Эрдэс, Улаан, Цав, Хэнтий аймгийн Мөнгөн-Өндөр, Цагаанчулуут, Өндөрцагаан, Могдой, Сүхбаатар аймгийн Төмөртэйн цайр, Арын нуур, Нүхт даваа, Егүзэрийн ховор ба холимог металлын орд газрууд, Цагаанчулуут, Хөх-Өндөрийн алтны орд газар, Дорнодын Тамсагбулагийн газрын тос, Мардайн ураны орд газар орно.

5. Эдэлбэр газрын бүс: Энэ бүсэд томоохон хотууд, сум, суурин газар, тэдгээрийн орчмын эдэлбэр газар, зам, шугам сүлжээний 1407,13 мян. га газар орно. Энэ нутаг дэвсгэрт байгалийн хам бүрдлүүд бүрэн эвдэгдсэн, хүний байгальд үзүүлэх нөлөөлөл нь эргээд хүнд гамшгийн хэмжээнд хүртэл буюу бохирдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэд дахин их болсон экологийн байдлыг сайжруулах бүс орно. Энэ бүсэд

ихэнхдээ хээр, талын ландшафт зонхилно. Өндөрхаан хот, Чойбалсан, Баруун-Урт зэрэг аймгийн төв, Бор-Өндөр, Хажуу Улаан, Бэрх, болон сум, сангийн аж ахуйн төвүүдийн эдэлбэр газар зэрэг хөрс усны бохирдолтой суурин газрууд багтана.

6. Газар тариалангийн бүс: Зүүн бүсийн газар тариалангийн эдэлбэр газрын ашиглалтын одоогийн байдлыг авч үзвэл тариалангийн нийт 181753 га талбайтай. Ашиглаж байгаа талбай 104811 га бий. Атаршсан талбай 76942 га байна. Ашиглалтгүй талбайн эзлэх хувь 23,6 байна. 1990 оны байдлаар зүүн бүсийн гурван аймгийн (Хэнтий, Дорнод, Сүхбаатар) тариалангийн талбай нь 200000 га буюу нийт тариалангийн талбайн 16%-ийг эзэлж байжээ. Өмнө нь ашиглаж байсан тариалангийн талбайн 80 гаруй хувь атаршиж ашиглагдахгүй болсон байна. Сүүлийн жилүүдийн байгаль, цаг уурын таагүй нөлөөлөл нь мал аж ахуйн салбарт төдийгүй газар тариалангийн үйлдвэрлэлд илүү нөлөөлж байна. Нэг га-гийн дундаж ургац улсын дунджаас 2,5-3 дахин бага байна. Зүүн бүсийн тариаланд ашиглаж болох нөөц газрын 90 гаруй хувь нь Дорнод аймгийн Халх голын орчимд байна [5].

Дүгнэлт 25 cm, respectively

Зүүн бүс нутаг нь хүн амын нягтрал, суурьшил багатай учраас байгаль орчин нь харьцангуй унаган төрхөө хадгалан үлджээ. Энэ бүс нутаг нийтдээ 28620.9 мян. га талбайтай бөгөөд Монгол Улсын газрын сангийн 18.3 хувь болж байна. Энэ бүс нутаг гадаргын усны нөөц ихээхэн дутмаг, хуурайшилт, байгалийн гамшгийн давтамж ихтэй, хөрсөн бүрхэвч нь элэгдэл, эвдрэлд амархан өртөмтгий зэрэг экологийн эмзэг орчинтой юм. Зүүн бүсэд биологийн өвөрмөц төрөл, зүйл бүхий тал хээрийн унаган ландшафтыг хадгалан үлдсэн дархан газраас байгалийн дурсгалт газар хүртэл ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан 3208200 га нутаг дэвсгэрийг хамарсан 21 газартай. Бэлчээрийн дундаж ачаалал бага, мал сийрэг байрлалтай ч гэсэн бэлчээрийн талхагдал Дорнод аймгийн Матад, Халх гол, Хөлөнбуйр, Сэргэлэн, Цагаан-Овоо, Сүхбаатар аймгийн Мөнххаан, Эрдэнэцагаан, Сүхбаатар, Уулбаян, Баяндэлгэр, Онгон, Наран, Түвшинширээ сумдын нутагт илүү ажиглагдаж байна. Өнөөгийн байдлаар 1902700 га тариалангийн талбайтай. Өмнө нь ашиглаж байсан тариалангийн талбайн 80 гаруй хувь атаршуулсан байна. Бүсийн нийт газар нутгийн 5.7 хувийг буюу 1482020 га талбайд ой тархсан байна. Одоогоор жилдээ 20.0 гаруй мянган шоо метр мод бэлтгэж жилд дунджаар 400 га-д ойн нөхөн сэргээлт хийж байна. Зүүн бүсийн нийт газрын сангийн 93.3 хувийг хөдөө аж ахуйн, 0.3 хувийг хот суурингийн, 5.7 хувийг ойн сангийн, 0.4 хувийг усан сангийн, 0.2 хувийг зам, шугам сүлжээний, 0.03 хувийг нөөц газар тус тус эзэлж байна. Өнөөгийн байдлаар 119260 га талбайд уул уурхайн олборлолт явагдаж үүнтэй холбоотойгоор хөрсний эвдрэл ихсэж байна. Геологи хайгуул, уул уурхайн үйлдвэрлэлийн явцад ухаж малтсан, эвдэрч элэгдсэн, бохирдож доройтсон 249,2 км² талбай бий. Энэ бүсд 757,5 км² элс тархсан байна.

Ашигласан ном

1. Ландшафтное планирование: принципы, методы, европейский и российский опыт. Иркутск: Изд-во Институт Географии. СО РАН. -141с: цв.ил.
2. Корытный А.М Бассейновая концепция в природопользования. Иркутск. Изд-во. Институт Географии.СО РАН. 2001. -141с
3. Территориальное развитие г. Байгальска и его пригородной зоны. Иркутск из-во ИГ СО РАН 2003
4. Экологически ориентированное планирование землепользования в байкльском регионе. Район дельты реки Селенги Иркутск из-во ИГ СО РАН 2002

5. Авирмэд.Э., 2015. “Хэнтий аймгийн ландшафт-нутаг дэвсгэрийн ашиглалт, зохистой бүсчлэл” дэд сэдвийн эрдэм шинжилгээний тайлан (2,5хх), УБ
6. Бадарч Н., Цэгмид Ш., Цэрэнсодном Ж., 1965. Монгол орны дорнод хэсгийн ландшафт ба байгалийн мужууд. УБ, 72-р хуудас
7. Дорнод аймаг. Статистикийн товчоон, УБ. 2014
8. Дорнод аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2016 он)
9. Мягмарсүрэн Д, А.Намхай., 2015. Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгууд. УБ. /47, 71, 110, 142-р хуудас
10. Оюунгэрэл. Б., 2004. “Тусгай хамгаалалттай газар нутаг”. УБ.
11. Сүхбаатар аймгийн нийгэм эдийн засгийн байдал. 2014/2
12. Х.Рихтер, Х.Бартель, Г.Хаазе., 1959. Монгол орны дорнод хэсгийн ландшафт
13. Хэнтий аймаг. Статистикийн товчоон, УБ. 2014
14. Хэнтий аймгийн статистикийн эмхэтгэл, Чингэс хот. 2015